



109

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 46

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 997,150,000 /есөн зуун ерэн долоон сая нэг зуун тавин мянга/ төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн Сайнцагаан сумын Наймдугаар цэцэрлэгийн барилга, эд хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Сайнцагаан сумын Наймдугаар цэцэрлэгийн эрхлэгч (Л.Оюун)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 7 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын
30-ний өдрийн 76 тогтоолын хавсралт

**Сайнцагаан сум Наймдугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд
бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо	Дүн
1	Хүүхдийн тоглоомын талбай	м ²	44,496	550	24,472,800
2	Холбооны шугам	м	10,500	153	1,606,500
3	Цахилгаан шугам	м	47,000	112	5,264,000
4	Цэцэрлэгийн барилга	ш	767,758,340	1	741,358,340
5	Бохирын шугам	м	310,000	142	44,020,000
6	Гадна дулааны шугам	ш	680,000	165	112,200,000
7	Явган зам талбай	м ²	26,792	455	12,190,360
8	Гадна гэрэлтүүлгийн шон	ш	265,500	12	3,186,000
9	Гадна тоглоом /том/	ш	5,200,000	1	5,200,000
10	Гадна тоглоом /жижиг/	ш	1,600,000	3	4,800,000
11	Гадна хашаа	м	91,400	180	16,452,000
12	Цэвэр усны шугам	м	160,000	165	26,400,000
Барилга байгууламжийн дүн				1939	997,150,000